

“ХӨВСГӨЛ” ХК

2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

№ 25/1

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.5, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-г тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 12:00 цагт цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.
4. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2023 оны 3 дугаар сарын 22-ны өдөр хүргүүлсүгэй.
5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, “Ард Секюритиз УЦК” ХХК-ийн цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2023 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, холбоотой бусад баримт бичгийг бэлэн болгож 2023

оны 3 дугаар сарын 24-ны өдрийн дотор хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.

7. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2023 оны 4 дугаар сарын 24-ний өдрийн 12:00 цагаар тасалбар болгосугай.
8. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга: Г.Уянга

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

“Ард Даатгал” ХК-ийн Эрсдэлийн газрын захирал Ц.Тайшир

“Хөвсгөл” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ

9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:

“Ард Секюритиз ҮЦК” ХХК-ийн Дотоод хяналтын менежер Д.Энхбилэг

Тооллогын комиссын гишүүд:

“Ард Секюритиз ҮЦК” ХХК-ийн Дата аналит И.Дөлгөөн

“Ард Секюритиз ҮЦК” ХХК-ийн Хуульч Г.Урангоо

10. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Г.Сэлэнгэ-д даалгасугай.

ДАРГА



Г. УЯНГА